



ХӨДӨЛМӨРИЙН САЙД
Я.САНЖМЯТАВ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.07 № 3/27

Зөрчил арилгах тухай

Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тус сангийн батлагдсан төсөвт зардлаас гадуур 76,613,400.0 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйл 23.3-д: “ХЭДС-гийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн **Шаардах нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, зохих заавар, журмын дагуу зарцуулж байх
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 1-ний дотор УАГ-т ирүүлэхийг Хөдөлмөрийн яамны ССБТГ-ын дарга С.Наранцогт, Ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт хариуцуулав.

АУДИТОР

Handwritten signature of the Auditor

П.ЧАНЦАЛДУЛАМ

УХА0122